

**Б. Лхамсүрэн**

**29. Бээжингийн Засгийн газраас Хятадын цэргийн эрхтэн, иргэний эрх баригчдад явуулсан илгээлтээс (1924)**

Тус Засгийн газрын үзэж байгаагаар Орос ба Гадаад Монголын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийг даруй хүчингүй болговол зохино. Оросын төлөөлөгч нь зөвхөн хуучин Орос улсаас гурав дахь оронтой байгуулсан гэрээнүүд Хятадын суверенитетэд харшилбал хүчингүй болгож болох юм хэмээгээд Зөвлөл Орос Гадаад Монголтой тогтоосон гэрээ хэлэлцээрийг хүчингүй болгохыг зөвшөөрөхгүй байгаа юм. Гэтэл эдгээр гэрээ хэлэлцээрээр Гадаад Монголыг тусгаар тогтносон орон гэж үзэж Оросын Засгийн газар өөрийн элчин төлөөлөгчийг илгээсэн учир энэ нь Хятадын суверенитетийг хүндэтгэнэ гэсэн зүйлд шууд харшилна.

China Year Book. 1924, p. 883.

**30. ЗХУ-ын гадаад хэргийн ардын комиссар Чичериний мэдэгдлээс (1925)**

Тифлис хотноо хуралдсан ЗСБНХУ-ын Төвийн Гүйцэтгэх Хорооны II их хурал дээр Г.Чичерин үг хэлэхдээ «Бид БНМАУ-ыг БН Хятад улсын хэсэг гэж хүлээхдээ, Монгол улс Хятадын зүгээс дотоод хэрэгт оролцохыг үл зөвшөөрөх төдийгүй гадаад бодлогоо биеэ дааж явуулах өргөн автономит эрхтэй гэж үздэг» гэжээ.

А. Қалинников. Революционная Монголия. М., 1925, с. 95.

**31. Зөвлөлтийн бүрэн эрхт төлөөлөгч П. М. Никифоровын тэмдэглэлээс (1925. VII. 12)**

Өнөөдөр Чичеринтэй ярилцаж Монголд бүрэн эрхт төлөөлөгчөөр явах саналыг хүлээн авав. Монголд бидний тавих зорилтын тухай Чичериний дэвшүүлсэн үндсэн зүйлүүд нь:

Гадаад Монголын талаар, «БН Монгол улс Хятадын ивээлийн доор өөртөө засаж биеэ даахыг бид хэлбэрийн хувьд тунхаглах боловч хэрэг дээр улс төр, эдийн засгийн байгууллын хувьд Монголыг Зөвлөлтийн хэлбэрт ойртуулахын тул бид ажиллана».

Дотоод Монголын талаар. «Дотоод Монголыг өөртөө нийлүүлэх гэсэн Монголын Засгийн газрын хүслийг бид Хятад дахь манай улс төрийн байдлын улмаас татгалзана. Монголыг нийлүүлэх нь бидний нөлөөлөл хэмээн ойлгогдож, Хятадын олон нийтэд дургүйцэл төрүүлнэ».

Урианхайн талаар. «Урианхайг бид Хятадын ивээл доор Монголын нэгэн адил өөртөө засах эрхтэй байх тусгаар БН улс гэж үзэх учир түүнийг Монголтой нэгтгэхийг татгалзана».

Личный дневник полпреда СССР П. М. Никифорова (июль 1925 по май 1927). с. 1.

32. Коминтерны төлөөлөгч Т. Рыскуловын илтгэлээс (1925. XII. 15)

...Монгол-Хятадын харилцааны асуудал дахин гарч ирлээ. Манай Элчин төлөөлөгчийн газрын ажилтан болон монголчуудтай хэдэн удаа Зөвлөлдсөний дараа энэ асуудлын талаар бидний баримтлах тактикийн бодлого зарчмын хувьд бүрэлдэж байх мэт. Энэ бодлогыг дараах байдлаар барагцаалан тодорхойлж болох. Үүнд:

\* Түрүүч нь 1992 оны № 2-т.

1. Монгол нь хэрэг дээр тусгаар тогтносон бүгд найрамдах ард улс байх ёстой бөгөөд энэ талаар Монголын ард түмний хүсэл зоригийг бүрэн илэрхийлж, Монголыг биеэ даасан улс болгох хууль эрхийн эхлэлтийг тавьсан Ардын Их Хурал тусгаар тогтнох энэхүү бодот байдлыг нотолсон билээ.

2. Хятадууд Караханд энэ талаар хандахад түүний эзэлсэн байр суурь нь Монголыг Хятадын өөртөө засах хэсэг хэмээн хүлээгээд монголчуудтай өөрсдөө хэлэлцэн тохиролцохыг хятадуудад санал болгожээ.

3. Хятадад очих Монголын төлөөлөгчийн байр суурь нь Монголын ард түмэн тусгаар тогтносноо, хүлээн зөвшөөрүүлэхийг эрмэлзэж байгаа ба Монголыг дахин Хятадын Милитаристуудын захиргаанд оруулах нь Хятадын ард түмний сонирхолд үл нийцэх бөгөөд Хятадын ард түмэн засгийн эрхийг гартаа авсан цагт найрамдан суух нь өөр хэрэг.

Монголчууд хятадуудтай санал нийлэхгүй буцаж ирэх болно. Хэрэв хятадууд цэрэг ирүүлбэл Монголчууд үзэлцэнэ... Ийнхүү тусгаар тогтносон Монгол улс бүр мөсөн ил гарч, олон улсын дипломатын зүгээс зөвшөөрөгдөх болно. Монголын тухай Караханы хэлснээр, дипломатын хувьд СССР нь Монголын асуудлаар эвгүй байдлаас гарах болно.

4. Хэрэв монголчууд тусгаар тогтнолын хатуу байр сууринаас өчүүхэн төдий ухарч, Хятадын өөртөө засах хэсэг байхыг зөвшөөрөн гарын үсэг зураад дараа нь эрхээ олж авна гэвэл туйлын засаршгүй алдаа болно.

5. Монголын Засгийн газрын баримталж байгаа байр суурь нь Монголын ард түмний санаа зоригийн илэрхийлэл мөн бөгөөд СССР холбогдолгүй гэдгийг Монголын төлөөлөгчдөөс Хятадын олон нийт болон олон улсын дипломатын өмнө бүхий л боломжтой аргаар нотолбол зохино.

Личный архив В. И. Юдина (секретаря советского представительства в Монголии). Инв. №

56

### **33. Элчин сайд Буянчуулганаас Гадаад яамны удирдлагад бичсэн албан захидлаас (1926. V. 8)**

СССР улсын бага хурал дээр Гэндэн нарыг урьж үзүүлснээс гадна мөн өдөр тус хуралд СССР-ээс гадаад олон улстай хэрхэн харилцаж буйг дэд комиссар Литвинов өргөн илтгэсэн боловч Монголтой харилцах тухай дурдаагүйн учрыг Гэндэн асуулгахыг хүссэний дагуу Гадаад яамны Алс Дорнодын хэлтсийн даргаас асуухад... Жинхэнэ улс төрийн талаар хэлэлцвээс манай улс Бээжинд гэрээ тогтооход Хятадын суверенитетийг хүлээсэн боловч танай төлөөлөгчийг хүлээн аваад суулгаж буй... Ирээдүй цагт Монгол, Хятад улсаас бүр мөсөн салж бүрэн эрхтэй улс болон жинхэнэ хуулийн ёсоор хүлээгдэх буй за. Бид нар тэрхүү хэлэлцээнд Монгол бүрэн эрхтэй байх нь зүйтэй хэмээн хэлэх магадгүй. Монголын тухай энэ хуралд хэлэх болохул сайнаар хэлэхээс өөр зүйлгүйгээс гадна энэ удаа улс төрийн хэргийн ёсоор тусгай албаны илтгэлд оролцуулан хэлэлцэх нь үл зохилдоно гэжээ.

ГХТА. Ф. 2, х.н. 112, 2-т.

### **34. БНМАУ-ын Засгийн газрын тунхаг бичгээс (1929. 4-р сар)**

Бидний монгол ард түмэн болваас нийтийн их хэргийг хянаж цаг үест нийлүүлэн нэгэнт ийнхүү бусдын дарлалаас ангижирч, өөрийн эрх чөлөөтэй байдлыг байгуулан тогтнож буй зэрэг явдлыг Дундад улсын Засгийн газар ба тэдний олон ард иргэн, албаны газрууд цөм тодорхой мэдсээр болох атал энэ мэт өөрийн харьяат нэгэн муж мэтээр үзэж, бичиг зарлалыг ирүүлж буй нь их л гайхалтай хэрэг болно. Үүнд Дундад улсын Засгийн газраас манай Монгол улсыг зөвшөөрөн

хүлээж харилцан найрамдал байгуулсугай хэмээх аваас манай Засгийн газраас нэгэн адил зөвшөөрөн хүлээж харилцан найрамдал байгуулж болох ба, түүнээс өөр бидний ард олны өөрсдийн хүчээр тэмцэлдэн байгуулсан бүрэн эрхтэй засаг төр ба ард олны эрх чөлөөг хэмжээлэх хэмээх буюу урьд адил Дундад улсын нэгэн муж буюу нэгэн хэсэг болгоно гэх зэргийн хэлэлцээн гаргах аваас бидний улс хэзээ ч хүлээж огт чадахгүй бөгөөд эл бичиг захидлыг хамааран хэлэлцэх зүйлгүй учрыг зохих олон газруудад нийтээр зарлаж гүйцэтгүүлэхээр тогтов.

БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл. 1929, 4-р сар. Дугаар 45.

### **35. Хятадын Гадаад яамны мэдэгдлээс (1930. V сар)**

Гадаад явдлын яам Хятад, Оросын хоорондын элдэв чухал асуудал, нэн ялангуяа Монголд холбогдох асуудлыг зүй зохисоор шийдвэрлэхийг эрмэлзэж байна... Орос улс Монгол дахь аливаа онцгой сонирхлоос нэгэнт татгалзсан ба шинээр эрэлхийлэх ёсгүй нь илт билээ. Монголын ард түмэн Зөвлөлт хөршийнхөө сүрдүүлэгт автахаас сэрэмжилж, бүхэл улс орны эвнэгдлийн төлөө төв засгийн газрын удирдлагын доор тэмцвээс зохино. Монгол ба Төвдийн гадаад харилцааг зохицуулах эрх мэдэл төв засгийн газарт орших бөгөөд энэ талаар нутгийн эрх баригчид гагцхүү гадаад явдлын яамны заалтаар ажиллаж болох юм.

Gerard M, Friters. Outer Mongolia and its international positions.  
Baltimore, 1949, p. 200.

### **36. Элчин сайд Цэенрэгзэнгээс Гадаад яамны сайд орлосон Намсрайд ирүүлсэн албан захидлаас (1931. IV. 30)**

Нөхөр Чойбалсан Холбоот улсын Гадаад яамны сайд орлосон нөхөр Карахан лугаа уулзаж ярилцсан бөгөөд мөн ярилцааны дотроос хэдэн зүйлийг авч чухал болгон мэдэгдэх нь: Хятад ба СССР хоёр улсын дундад харилцааг сайжруулах тухай Хятад улсаас тусгай төлөөлөгч Мо Дүхүй хэмээх хүнийг Москвад томилон ирүүлсэн бөгөөд эдүгээ энэхүү конференц хэмээх хурлыг нээж энэ хэр гагцхүү Хятадын зүүн төмөр замын асуудлыг чухал болгон хэлэлцэж буй. Төлөөлөгчөөс Нөхөр Карахан лугаа энгийн яриа хэлэлцэхэд Монголын тухай асуудлыг тавихыг хүсэх хэрд Караханаас хариулсан нь манай улсаас Монгол улсыг хэрхэн ямраар үзэх тухай 1924 онд Хятад ба СССР хоёр улсын дунд байгуулсан гэрээний дотор бүрэн тодорхойгоор буй тул эдүгээ дахин авч хэлэлцэх явдалгүй бөгөөд нөгөөтээгүүр эрхэм Хятад улсаас Монгол улсын тухай аливаа нэгэн асуудлыг хэлэлцэх, лавлахыг хүсвэл бүрэн эрхт БНМАУ-ын Засгийн газар буюу СССР улсад бүхий элчин сайд лугаа ярилцваас зохих бөгөөд манай Засгийн газраас Монгол улсын төлөөнөө дур мэдэн аливаа нэгэн хэргийг яахан тийм хэмээн үйлдэж үл болохыг та бэлхнээ мэдмүй зэ хэмээн хариулсан бөгөөд энэхүү Хятадын төлөөлөгчөөс энэ удаа Монголын тухай асуудлыг тавихгүй боловч ерөнхий дор хэзээд санаж хүсэж буй болой гэжээ.

### **37. Японы Гадаад яамны дэд сайд Токичи Таңацагийн бичсэнээс (1932)**

Миний бодлоор, тусгаар тогтносон Монгол улсыг Япон хүлээн зөвшөөрч, түүнтэй албан ёсны харилцаанд орвол зохино. Тусгаар тогтносноо арваад жил дотоод гадаад талаасаа харуулсан улсыг тусгаар тогтносон гэж үзэхэд гайхмаар юм огт байхгүй. Японоос Монголыг зөвшөөрөх буюу Монгол Тийнхүү зөвшөөрснийг хүлээн авахад умрын аварга л зам хөндөлсөхгүй бол саад болох ноцтой шалтгааныг би олж харахгүй байгаа бөгөөд тэгж хөндөлсөх нь бүх зүйлийг харгалзан үзвэл итгэл багатайгаас гадна үйл явдлаас нөхцөлдөөгүй таамаглал билээ.

G. M. Friters. Outer Mongolia and its international positions p. 236.

**38. Монгол-Зөвлөлтийн харилцан туслалцах тухай аман хэлэлцээр (1934)**

БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгчид ЗХУ-д айлчлах үеэр 1934 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр «цэргийн довтолгооны занал аюулуудыг аль болох аргаар зайлуулахаар урьдаас сэргийлэх хэрэгт бие биедээ туслах ба мөн хэрэв Бүгд Найрамдах Монгол Ард Улс буюу Зөвлөлийн Засагт Нийгэм журамт Бүгд Найрамдах Холбоот Улсыг ямар нэгэн гуравдугаар этгээдээс довтолбол бие биедээ тусламж үзүүлнэ» гэсэн хүндэт ам хэлэлцээр байгуулжээ.

БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. I боть, 34 дэх тал.

**39. Японы Гадаад яаманд Зөвлөлтийн элчин сайд Юренивийн гардуулсан мэдэгдэл (1935. VII. 6)**

Монгол-Манжуурын хил дээр болж байгаа явдал болон Манжуур станцад хэлэлцээ явагдаж, тэдгээрт Квантуны армийн командлал идэвхтэй оролцож байгааг Зөвлөлт засгийн газар анхааралтай ажиглаж байна. Өөрийн хил хязгаарыг хамгаалах үүднээс Гадаад Монголын нутаг дэвсгэрийн халдашгүй байдлыг сонирхож байдаг Зөвлөлт засгийн газар, Япон-Манжийн цэргийн үйл ажиллагаа нь Япон-Зөвлөлтийн харилцааг хурцатгахад хүргэж болзошгүй гэж сэтгэл их түгшиж байна. Өнөөгийн Хэвийн тайван харилцааг хадгалахыг Зөвлөлтийн нэгэн адил сонирхож байдаг Японы Засгийн газар, Манж-Монголын хилийн тайван байдлыг хангах талаар Квантуны командлалд зохих заалт өгнө гэж Зөвлөлт засгийн газар итгэж байна.

Документы внешней политики СССР. Т. XVIII. с. 438—439.

**40. Америкийн сонин сурвалжлагч Рой Говардын асуултад И.В.Сталины өгсөн хариултаас (1936. III. 1).**

Рой Говардын асуултад Сталинаас хариулахдаа, хэрэв Японоос БНМАУ-ыг довтолохоор шийдвэрлэж, түүний тусгаар тогтносон бүрэн эрхт байдалд халдах аваас бид аргагүй туслах болно. «Японоос Уланбаатарыг эзлэн авахаар тавьж байгаа бодлого нь эцэстээ СССР улсыг шийдвэртэйгээр хөдлөхөд хүргэх үү?» гэж асуухад Сталинаас «Тийм ээ, хүргэнэ» гэжээ.

И. В. Сталин, Беседа с председателем американского газетного объединения «Скриппс-Говард ньюспейпер» г-ном Рой Говардом, 1937, с. 5

**Ховдыг чөлөөлсний 80  
жилийн ойд**

**ХОВД ХОТЫГ ЧӨЛӨӨЛСӨН ТУХАЙ  
ХОЁР БАРИМТ**

Хэрээд Л. Жамсран\*

Цагаагчин гахай жил буюу 1911 оны 12 дугаар сард Их хүрээнд Халхын хүрээний бүх цэргийг түр ерөнхийлөн шийтгэх газар гэгч үндэсний эрх чөлөөний хувьсгалт эргэлтийг зохион байгуулах байгууллага байгуулагдаад олон монгол чуулган хошуудыг өөрсдийн нутагт суугаа Чин улсын жанжин, хэрэг шийтгэх сайд, түүнчлэн хуувийн сайд нарыг нэн даруй үлдэн зайлуулахыг зарлан тушаасан билээ. Хамгаас түрүүнд Их Хүрээний хэрэг шийтгэгч сайд Сань До амбан гэгч,

\* Түүхийн ухааны дэд эрдэмтэн.